

НЭГ.ҮНДЭСЛЭЛ, СУДЛАГДСАН БАЙДАЛ

Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 батлагдан, Эрүүл мэндийн салбарт эрх зүй, зохион байгуулалтын шинэчлэл хийгдэн, Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого батлагдан хэрэгжилтээ хүлээж байна. Энэхүү үзэл баримтлал, эрх зүйн орчны шинэчлэлийг хэрэгжүүлэхэд эрүүл мэндийн удирдах ажилтны мэдлэг, ур чадвар чухал юм.

2015 оны эрүүл мэндийн статистик мэдээллээр 3244 эрүүл мэндийн байгууллагад 871 удирдах ажилтан ажиллаж байна. Үүүнийг байршил тусламж, үйлчилгээний шатлалаар авч үзвэл анхдагч шатлалд 51, хоёрдогч шатлалд 112, гуравдагч шатлалд 63 бусад эрүүл мэндийн байгууллагад 645 удирдах ажилтан ажиллаж байна гэсэн тоон үзүүлэлт бий.

Мөн удирдах ажилтны сургалтын хэрэгцээг тодорхойлох зорилгоор хэд хэдэн судалгаа хийгдсэн бөгөөд. Үүнд:

- 1998 онд Ц.Содномпил, М.Туяа, Ш.Оюунбилэг нар “Эрүүл мэндийн менежерийн сургалтын зарим асуудалд” ажил нь эрүүл мэндийн удирдагч нарын сургалтыг улам сайжруулахад хөдөө орон нутагт зайнаас явуулах, сургалтыг сэдэвчилсэн, урт богино хугацаанд тодорхой үе шаттайгаар явуулах, сургалтын дараа үйл ажиллагааны ба үр дүнгийн дүгнэлтийг тогтмол хийх, сургалтанд хамрагдсан удирдагчдыг тогтвортой ажиллуулах зэрэг зүйлийг тодотгон гаргасан байна.
- 2014 онд Л.Ширнэн, Б.Доржмягмар нар “Эрүүл мэндийн салбарын удирдах ажилтны судалгаа”-аар 56,4% нь удирдлагын чиглэлээр мэргэшээгүй, сургалтанд хамрагдаагүй, удирдлага, эрүүл мэндийн удирдлагаар мэргэжил олгох, дээшлүүлэх, сэдэвчилсэн богино хугацаатай сургалтуудыг зохион байгуулах зэрэг дүгнэлт, зөвлөмжийг гаргасан байна.
- 2016 оны 9 сард АХБ-наас “Эмнэлгийн бие даасан байдлыг бэхжүүлэх техник туслалцааны төсөл”-ийн хүрээнд “Эмнэлгийн удирдлагын чиглэлээр сургалт явуулдаг байгууллагуудын түргэвчилсэн үнэлгээ” хийгджээ.

1996 оноос эхлэн ЭМХТ нь Эрүүл мэндийн удирдлагын анхны сургалтуудыг Үндэсний хэмжээнд зохион байгуулсан баялаг туршлагатай бөгөөд өнөөг хүртэл 140 гаруй удаагийн сургалтаар 5000 шахам удирдах ажилтан, эмч мэргэжилтэн “Эрүүл мэндийн удирдлага”-аар чадавхижуулан, оюуны хөрөнгө оруулалт хийсэн байна. Гэсэн хэдий ч сүүлийн жилүүдэд эрүүл мэндийн удирдлагын сургалтын тасралтгүй тогтолцоо алдагдаж, сургалтын хэрэгцээ өсөн нэмэгдэж байна. Нөгөө талаас удирдах ажилтны бүтцийн шинэчлэл хийгдэж, эрүүл мэндийн удирдлагаар мэргэшсэн хүний нөөцийн тоо, удирдах ажилтнуудад шаардлагатай сургалтыг тогтоох.

Мөн эрүүл мэндийн бодлого, шийдвэрүүдийг зөв томъёолох, үр дүнтэй хэрэгждэг болоход тодорхой хувь нэмэр оруулах үүднээс ЭМХТ-н Бодлогын судалгаа, удирдах ажилтны сургалтын алба шинэ арга аргачлал хэрэгжүүлэх, Эрүүл мэндийн удирдах ажилчдад зориулсан удирдах ажилтны сургалтын хөтөлбөрийг зохион байгуулах, илүү үр ашигтай хэрэгжүүлэх үүднээс сургалтын хэрэгцээг тодорхойлох шаардлагатай байна.

ЗОРИЛГО

Эрүүл мэндийн салбарын удирдах ажилтны сургалтын хэрэгцээг тодорхойлох.

ЗОРИЛТ

1. Эрүүл мэндийн салбарын удирдах ажилтны сүүлийн таван жилийн хугацаанд хамрагдсан сургалтын байдалд дүн шинжилгээ хийх.
2. Эрүүл мэндийн салбарын удирдах ажилтны сургалтын сэдэв, арга, хэлбэрийг тодорхойлох.

ХОЁР.СУДАЛГААНЫ МАТЕРИАЛ, АРГА ЗҮЙ

Судалгааны арга зүй: Судалгаанд тоон болон чанарын судалгааны аргыг ашиглав.

Тоон судалгаагаар асуулга/анкетын аргаар явуулах бөгөөд тоон судалгааны мэдээллийг SPSS програм ашиглан компьютерт бэлтгэн оруулж, мэдээллийн боловсруулалт, статистик шинжилгээнд мөн SPSS программыг ашиглана.

Чанарын судалгаагаар эрүүл мэндийн байгууллагын газрын дарга, захирал нартай “TELEMEDICINE” ашиглан доорх зүйлсийг дотруулан ганцаарчилсан ярилцлага хийнэ.

Үүнд:

Удирдах ажилтанд сургалтын ямар сэдвээр, ямар арга, хэлбэрээр, суралцах хэрэгцээтэй байгааг тодруулах зорилгоор

- Удирдах ажилтанд ямар сургалтын арга хэлбэр илүү оновчтой гэж үзэж байна вэ?
- Богино хэмжээний ямар сургалт шаардлагатай байна вэ?
- Урт хугацааны ямар сургалт шаардлагатай байна вэ?
- Удирдах ажилтаны сургалтын хугацаа ямар байвал илүү үр дүнтэй гэж үзэж байна вэ?

Судалгааны хамрах хүрээ:

- ЭМЯ-ны харьяа УНТЭ, УГТЭ, ХӨСҮТ, СЭМҮТ, ЭХЭМҮТ, ЭСҮТ, ХТС, АӨСҮТ, ЗӨСҮТ, ГССҮТ, Дорнод БОЭТ, Өвөрхайнгай БОЭТ, Өмнөговь БОЭТ нийт 13 байгууллага,
- Нийслэлийн эрүүл мэндийн газар, Амгалан амаржих газар, Өргөө амаржих газар, Баянзүрх дүүргийн нэгдсэн эмнэлэг, Чингэлтэй дүүргийн эрүүл мэндийн төв, Сүхбаатар дүүргийн эрүүл мэндийн төв, Сонгино хайрхан дүүргийн эрүүл мэндийн төв нийт 7 байгууллага
- Архангай, Төв, Баянхонгор, Орхон, Завхан, Сүхбаатар, Ховд, Хөвсгөл, Хэнтий, Дорноговь, Өмнөговь, Өвөрхангай, Дархан, Дундговь нийт 14 аймгийн Эрүүл мэндийн газар, нэгдсэн эмнэлэг, сум, өрх, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг нийт 272 байгууллага 3 түвшний 306 байгууллагын Дарга/захирал, Орлогч дарга/захирал, Алба/хэлтсийн дарга, Тасаг/нэгжийн эрхлэгч 781 удирдах ажилтнууд хамрагдав.

Судалгааны түүвэрлэлт: Түүврийн тоог дараах томъёог ашиглан 3244 эрүүл мэндийн байгууллагын 781 удирдах ажилтны статистик тоон мэдээллээс тооцоолон тогтоосон энэхүү түүвэрлэлт 95,4%-ийн үнэн магадлалыг хангана.

$$n = \frac{t^2 * w(1-w) * N}{N * \Delta^2_p + t^2 * w(1-w)}$$

- ❖ t-баталгааны коэффициентийг 95,4 хувийн үнэн магадлалтай байхаар t=2 авлаа
- ❖ w(1-w)- дунджаас хазайх хазайлтын квадрат буюу дисперсийг 0,25-аар тооцоолов
- ❖ N- эх олонлогийн хэмжээ
- ❖ Дельта- Алдааны хязгаар ба 0,05 аар авлаа
- ❖ n- түүврийн хэмжээ болно

Мэдээлэл цуглуулах хэрэгсэл: Тусгайлан боловсруулсан асуумж, тоон судалгааны хүснэгтэн загвар ашиглан эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт албан тоотоор хүргүүлэн, мэдээллийн нэгтгэлийг харьяа байгууллагуудаас ЕСХЕI файл болон цасаар авав

Мэдээлэл боловсруулалт: Эрүүл мэндийн байгууллагуудаас ирсэн мэдээллийг SPSS програмд хөрвүүлэн, шаардлагатай зарим мэдээллийг шүүн засварлан нэгтгэж дүн шинжилгээ хийв.

Үзүүлэлт	Чухал биш	Дунд зэргийн чухал	Чухал
Оноо/ балл	1	2	3
Түвшин	0-33,3	33,4-66,7	66,8-100

Үзүүлэлт	Чухал биш	Бага чухал	Дунд зэргийн чухал	Чухал	Маш чухал
Оноо/ балл	1	2	3	4	5
Түвшин	0-19	20-39	40-59	60-79	80-100

Судалгааны ажиллах хүчин: Бодлогын судалгаа, удирдах ажилтны сургалтын албаны мэргэжилтнүүд


Судалгааны бэрхшээл: Судалгаанд ирүүлсэн мэдээллийн зарим алдаатай, тодорхой бус мэдээллийг тодруулан үнэн, бодит байдлыг хангах мэдээллийг шүүн цэвэрлэж боловсруулах, үр дүнгийн тайланг нягтлан засварлахад хугацаа их зарцуулагдсан ба зарим шаардлага хангахгүй мэдээллийг хассан болно.

Мэдээлэл түгээх: Судалгааны үр дүнгийн тайланг ЭМЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газар, Бодлого төлөвлөлтийн газарт тус тус хүргүүлэв.

ГУРАВ.СУДАЛГААНЫ ҮР ДҮН

3.1 Эрүүл мэндийн салбарын удирдах ажилтны сүүлийн таван жилийн хугацаанд хамрагдсан сургалт


График 1. 2012-2016 оны хооронд удирдах ажилтны сургалтад хамрагдсан байгууллага



Нийт 17 эрүүлмэндийн байгууллагын Сум дундын эмнэлэг 0,8%, Сумын эрүүлмэндийн төв 6,9%, Эрүүлмэндийн газар 6,7%, Нэгдсэн эмнэлэг 7,5%, Өрхийн эрүүлмэндийн төв 8,5%, Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв 69,6% нь сургалтад хамрагдсан байна.


График 2. 2012-2016 оны хооронд удирдах ажилтны сургалтад хамрагдсан байдлыг албан тушаалаар нь

2012-2016 оны сургалтанд хамрагдсан байдал




Нийт 17 байгууллагын удирдах ажилтнуудын 8,5% Орлогч/дэд захирал, 23,1% Дарга/захирал, 25,6% Алба/хэлтсийн дарга, 42,8% Тасгийн эрхлэгч нар дийлэнх нь сургалтад хамрагдсан байна.

График 3. 2012-2016 оны хооронд удирдах ажилтны сургалтын хугацаа




Нийт зохион байгуулагдсан сургалтын 63% 1-2 хоногийн сургалт, 13% 3-4 хоногийн сургалт, 7% 5-6 хоногийн сургалт, 6% 7-14 хоногийн сургалт тус тус зохион байгуулагдсан байна.

График 4. 2012-2016 оны хооронд удирдах ажилтны сургалт зохион байгуулсан байгууллага



Дээрх графикаас үзэхэд 2% Нийгмийн эрүүлмэндийн хүрээлэн, 7% Удирдлагыны академи, 8% ЭМЯ, 8% Их дээд сургууль, 10% ЭМХТ, 12% бусад байгууллага, 53% нь буюу дийлэнх нь Төрийн бус байгууллага сургалт зохион байгуулсан байна.

График 5. 2012-2016 оны хооронд удирдах ажилтнуудад хийгдсэн сургалтын сэдэв




Нийт 17 байгууллагын удирдах ажилтнуудын ирүүлсэн 493 мэдээллээс Байгууллагын соёл ба хөгжил сургалт 5,7%, Хүний нөөцийн удирдлагын сургалт 6,9%, Чанарын удирдлагын сургалт 7,1%, Стратеги төлөвлөлтийн сургалт 8,7%, Удирдлагын сургалт 9,1%, Удирдлагын манлайллын сургалт 20,5% тус тус сэдвийн хүрээнд сургалт зохион байгуулагдсан байна.

График 6. Дийлэнх зургаан сургалтын сэдвийг албан тушаалаар нь харьцуулсан байдал



Удирдлагын манлайллийн сургалт 62% нь тасгийн эрхлэгч нарт, 22% нь алба/хэлтсийн дарга нарт, Удирдлагын сургалт 69% нь тасгийн эрхлэгч нарт, 18% нь алба/хэлтсийн дарга нарт, Стратеги төлөвлөлтийн сургалт 56% нь тасгийн эрхлэгч нарт, 28% нь дарга/захирал нарт, Чанарын удирдлагын сургалт 40% нь дарга/захирал нарт, 31% нь алба/хэлтсийн дарга нарт, Хүний нөөцийн удирдлага сургалт 53% нь тасгийн эрхлэгч нарт, 32% Алба/хэлтсийн дарга нарт, Байгууллагын соёл ба хөгжлийн сургалт 50% нь тасгийн эрхлэгч, 21% алба/хэлтсийн дарга нарт сургалт зохион байгуулагдсан байна.

График 7. Удирдлагын сургалтын зардлын байдал



Судалгаанд оролцогчдийн 9,3% нь улс зардал, 9,5% нь хувийн зардал, 73,4% байгууллагын зардлаар удирдах ажилтны сургалтад суралцсан байна. Мөн 7.7% нь хариулаагүй байна.


3.2 Хэрэгцээг тогтоох асуумж судалгааны үр дүн

График 8. Судалгаанд оролцогчдын хүйсийн байдал




Судалгаанд нийт 781 удирдах ажилтны 22,3% эрэгтэй, 77,7% эмэгтэй удирдах ажилтнууд оролцсон байна.

График 9. Судалгаанд оролцогчдын насны байдал




Судалгаанд нийт 781 удирдах ажилтны 0,3% 20-24 нас, 10,8% 25-29 нас, 13,4% 30-34 нас, 8,2% 35-39 нас, 12,2% 40-44 нас, 21,1% 45-49 нас, 20,4% нь 50-54 нас, 11,5% 55-59 нас, 1,9% 60-64 насны удирдах ажилтнууд оролцсон байна.

График 10. Судалгаанд оролцогчдын нийт ажилласан жил, эрүүл мэндийн байгууллагад ажилласан жил, удирдах ажилтнаар ажилласан жилийн харьцуулсан байдал




Судалгаанд нийт 781 удирдах ажилтны 17,5% нь 16-20 жил, 17,1% 21-25 жил 15,0% нь 1-5 жил эрүүл мэндийн байгууллагад ажилласан байна. Түүнчлэн 42,4 % нь 1-5 жил, 18,2% нь 6-10 жил зэрэг удирдах ажилтнаар ажилласан ажлын туршлагтай байна. Харин 8,4% нь 1 жил хүртэл удирдах ажилтнаар ажилласан буюу шинээр томилогдон ажиллаж байна.

График 11. Судалгаанд оролцогчдыг эрүүл мэндийн байгууллагаар нь



Судалгаанд 21,3% ССДТЭМТ, 18,5% ТЭТМТ, 18,0% ӨЭМТ, 15,4% ДНЭЭМТ, 11,9% АНЭ, 7,3% АНЭМГ, 6,9% БОЭТ эрүүл мэндийн байгууллага судалгаанд оролцсон байна.

График 12. Судалгаанд оролцогчдыг албан тушаалаар нь




Судалгаанд 46,6% Дарга/захирал, 26,4% тасгийн эрхлэгч, 21,5% Алба хэлтсийн дарга, 5,6% Орлогч дарга/дэд захирал нар оролцсон байна.

График 13. Удирдах ажилтны сургалтын хугацааг тодруулсан байдал




Нийт судалгаанд оролцогчдын дийлэнх 32,5% нь 1-5 өдрийн сургалт, 31,6% нь 7-14 өдрийн сургалтад суух боломжтой буюу хэрэгцээтэй байна. Түүнчлэн 16,1% нь 15-30 өдрийн сургалт, 6,6% нь 45-180 өдрийн сургалтанд суух боломжтой гэж хариулсан байна.

График 14. Удирдах ажилтны сургалтын хэлбэрийг тодруулсан байдал



Нийт судалгаанд оролцогчид 15% нь ажлын байран дах сургалт чухал биш, 45,3% нь зайн сургалт дунд зэргийн чухал буюу хэрэгцээ бага байна гэж үнэлсэн. Харин дийлэнх 83,2% нь танхимын сургалт чухал хэрэгцээтэй гэж үнэлсэн байна.

График 15. Удирдах ажилтны сургалтын төрлийг тодруулсан байдал



Нийт судалгаанд оролцогчид 51% нь анхан шатны буюу суурь мэдлэг олгох сургалт, 66,3% нь сэдэвчилсэн сургалт нь дунд зэргийн чухал хэрэгцээтэй байна гэж үнэлсэн. Харин дийлэнх 74,5% нь мэргэжил дээшлүүлэх сургалт, 67,8% мэргэшил олгох сургалт нь чухал хэрэгцээтэй гэж үнэлсэн байна.

График 16. Удирдах ажилтны сургалтын сэдвийг тодруулсан байдал



Нийт судалгаанд оролцогчидын дийлэнх нь 85,6% /4,4 балл/ нь Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, чанар хүртээмжийн сургалт, 80,6%/4,2 балл/ нь Эрүүл мэндийн байгууллагын стратеги төлөвлөлтийн сургалт, 78,9/4,2 балл/ нь Эмнэлгийн байгууллага дахь эрсдлийн удирдлагын сургалт нь маш чухал хэрэгцээтэй гэж үнэлсэн байна.

Хүснэгт 1. Удирдлагын сургалтын сэдвийг албан тушаалтай харьцуулсан байдал

№	Албан тушаал	Эрүүл мэндийн салбарын төлөв байдал, бодлогын тойм		Эрүүл мэндийн салбар дахь нооцийн удирдлага		Эрүүл мэндийн тусламж үйлчилгээн ий чанар хүртээмж		Эрүүл мэндийн хөтөлбөрийн төлөвлөлт, үнэлгээ		Эрүүл мэндийн байгууллагын стратеги төлөвлөлт		Эмнэлгийн н байгууллага дахь эрсдлийн удирдлага		Эмнэлгийн н байгууллага дахь мэдээлэл, харилцаа		Эрүүл мэндийн салбар дахь түншлэл, хамтын ажиллагаа		Бусад		Нийт	
		Хувь	Бал	Хувь	Бал	Хувь	Балл	Хувь	Бал	Хувь	Балл	Хувь	Бал	Хувь	Бал	Хувь	Бал	Хувь	Бал	Хувь	Балл
1	Албаны дарга	69.3	3.8	69.3	3.8	87.8	4.5	80.7	4.2	85.2	4.4	85.6	4.4	76.6	4.1	75.6	4.0	10.0	1.4	63.4	3.8
2	Дарга, захирал	68.0	3.7	68.0	3.7	84.6	4.4	72.7	3.9	81.2	4.2	78.0	4.1	75.0	4.0	73.0	3.9	17.3	1.7	61.1	3.7
3	Орлогч/ дэд захирал	79.7	4.2	79.7	4.2	90.6	4.6	73.4	3.9	82.0	4.3	86.7	4.5	78.9	4.2	78.1	4.1	15.6	1.6	65.0	4.0
4	Тасгийн эрхлэгч	67.7	3.7	67.7	3.7	84.8	4.4	68.7	3.7	75.7	4.0	73.3	3.9	70.4	3.8	74.0	4.0	12.1	1.5	58.5	3.6
Дундаж хувь		71.2		71.2		86.9		73.9		81.0		80.9		75.2		75.2		13.7		62.0	
Дундаж балл		3.8		3.8		4.5		4.0		4.2		4.2		4.0		4.0		1.5		4	

Судалгаанд оролцогч албаны дарга нарт 87.8% /4,5 балл/ нь Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийн сургалт, 85,6%/4,4 балл/ нь Эмнэлгийн байгууллага дахь эрсдлийн удирдлагын сургалт, 85,2%/4,4 балл/ нь Эрүүл мэндийн байгууллагын стратеги төлөвлөлтийн сургалт чухал хэрэгцээтэй байна.

Дарга/захирал нарт 84.6% /4,4 балл/ нь Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийн сургалт, 81,2%/4,2 балл/ нь Эрүүл мэндийн байгууллагын стратеги төлөвлөлтийн сургалт, 78,0%/4,1 балл/ нь Эмнэлгийн байгууллага дахь эрсдлийн удирдлагын сургалт чухал хэрэгцээтэй байна.

Орлогч/дэд захирал нарт 90.6% /4,6 балл/ нь Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийн сургалт, 86,7%/4,5 балл/ нь Эмнэлгийн байгууллага дахь эрсдлийн удирдлагын сургалт, 82,0%/4,3 балл/ нь Эрүүл мэндийн байгууллагын стратеги төлөвлөлтийн сургалт чухал хэрэгцээтэй байна.

Тасгийн эрхлэгч нарт 84.8% /4,4 балл/ нь Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийн сургалт, 75,7%/4,0 балл/ нь Эрүүл мэндийн байгууллагын стратеги төлөвлөлтийн сургалт, 74,4%/3,8 балл/ нь Эрүүл мэндийн салбар дахь түншлэл, хамтын ажиллагааны сургалт чухал хэрэгцээтэй байна.

Хүснэгт 2. Удирдлагын сургалтын сэдвийг эрүүлмэндийн байгууллагатай харьцуулсан байдал

№	Эрүүл мэндийн байгууллага	Эрүүл мэндийн салбарын төлөв байдал, бодлогын тойм		Эрүүл мэндийн салбар дахь нөөцийн удирдлага		Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмж		Эрүүл мэндийн хөтөлбөрийн төлөвлөлт, үнэлгээ		Эрүүл мэндийн байгууллагын стратеги төлөвлөлт		Эмнэлгийн байгууллага дахь эрсдлийн удирдлага		Эмнэлгийн байгууллага дахь мэдээлэл, харилцаа		Эрүүл мэндийн салбар дахь түншлэл, хамтын ажиллагаа		Бусад		Нийт	
		Хувь	Бал	Хувь	Бал	Хувь	Балл	Хувь	Бал	Хувь	Балл	Хувь	Бал	Хувь	Бал	Хувь	Бал	Хувь	Бал	Хувь	Балл
1	АНЭМГ	77.4	4.1	75.6	4.0	86.9	4.5	76.2	4.0	82.1	4.3	82.7	4.3	82.7	4.3	77.4	4.1	21.4	1.9	73.6	3.9
2	АНЭ	71.0	3.8	74.6	4.0	85.3	4.4	70.6	3.8	77.2	4.1	79.8	4.2	68.0	3.7	80.5	4.2	8.5	1.3	68.4	3.7
3	БОЭТ	69.1	3.8	69.1	3.8	78.3	4.1	69.1	3.8	73.0	3.9	69.1	3.8	64.5	3.6	65.8	3.6	9.2	1.4	63.0	3.5
4	Бусад	54.2	3.2	70.8	3.8	66.7	3.7	70.8	3.8	66.7	3.7	66.7	3.7	62.5	3.5	58.3	3.3	0.0	1.0	57.4	3.3
5	ДНЭЭМТ	69.6	3.8	71.0	3.8	89.5	4.6	79.3	4.2	80.7	4.2	86.9	4.5	76.1	4.0	76.1	4.0	13.1	1.5	71.4	3.9
6	ӨЭМТ	64.3	3.6	73.3	3.9	81.3	4.3	69.2	3.8	76.5	4.1	73.1	3.9	73.5	3.9	68.7	3.7	14.3	1.6	66.0	3.6
7	ССДТЭМТ	69.1	3.8	75.2	4.0	87.7	4.5	77.9	4.1	85.5	4.4	81.6	4.3	75.4	4.0	75.0	4.0	15.6	1.6	71.4	3.9
8	ТЭТМТ	68.4	3.7	75.5	4.0	87.7	4.5	69.8	3.8	84.2	4.4	76.9	4.1	77.4	4.1	75.2	4.0	17.2	1.7	70.3	3.8
Дундаж хувь		3.7		3.9		4.3		3.9		4.1		4.1		3.9		3.9		1.5		3.7	
Дундаж балл		67.9		73.1		82.9		72.9		78.2		77.1		72.5		72.1		12.4		67.7	

АНЭМГ-т 86,9% /4,5 балл/ нь Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийн сургалт, 82,7%/4,3 балл/ нь Эмнэлгийн байгууллага дахь эрсдлийн удирдлагын сургалт, 82,7%/4,3 балл/ нь Эмнэлгийн байгууллага дахь мэдээлэл, харилцааны сургалт маш чухал хэрэгцээтэй байна.

АНЭ-т 85,3% /4,4 балл/ нь Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийн сургалт, 80,5%/4,2 балл/ нь Эрүүл мэндийн салбар дахь түншлэл, хамтын ажиллагааны сургалт, 79,8,7%/4,2 балл/ нь Эмнэлгийн байгууллага дахь эрсдлийн удирдлагын сургалт маш чухал хэрэгцээтэй байна.

БОЭТ-д 78,3% /4,1 балл/ нь Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийн сургалт, 69,1%/3,8 балл/ нь Эрүүл мэндийн салбарын төлөв байдал, бодлогын тойм сургалт, 69,1%/4,3 балл/ нь Эрүүл мэндийн хөтөлбөрийн төлөвлөлт, үнэлгээний сургалт чухал хэрэгцээтэй байна.

ДНЭЭМТ-д 89,5% /4,6 балл/ нь Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийн сургалт, 86,9%/4,5 балл/ нь Эмнэлгийн байгууллага дахь эрсдлийн удирдлагын сургалт, 80,7%/4,2 балл/ нь Эрүүл мэндийн байгууллагын стратеги төлөвлөлтийн сургалт чухал хэрэгцээтэй байна.

ӨЭМТ-д 81,3% /4,3 балл/ нь Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийн сургалт, 76,5%/4,1 балл/ нь Эрүүл мэндийн байгууллагын стратеги төлөвлөлтийн сургалт, 73,5%/3,9 балл/ нь Эмнэлгийн байгууллага дахь мэдээлэл, харилцааны сургалт чухал хэрэгцээтэй байна.

ССДТЭМТ-д 87,7% /4,5 балл/ нь Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийн сургалт, 85,5%/4,4 балл/ нь Эрүүл мэндийн байгууллагын стратеги төлөвлөлтийн сургалт, 81,6%/4,3 балл/ нь Эмнэлгийн байгууллага дахь эрсдийн удирдлага чухал хэрэгцээтэй байна.

ТЭТМТ-д 87,7% /4,5 балл/ нь Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийн сургалт, 84,2%/4,4 балл/ нь Эрүүл мэндийн байгууллагын стратеги төлөвлөлтийн сургалт, 77,4%/4,1 балл/ нь Эмнэлгийн байгууллага дахь мэдээлэл, харилцааны сургалт чухал хэрэгцээтэй байна.

Байгууллагын хувьд удирдах ажилтны нийт сургалтын хэрэгцээ 73,6% нь АНЭМГазарт, 71,4% нь ДНЭЭМТөвд, 71,4% нь ССДТЭМТ-д тус тус чухал байна.

Хүснэгт 3. Удирдлагын сургалтын төрлийг эрүүл мэндийн байгууллагатай харьцуулсан байдал

№	Эрүүл мэндийн байгууллага	Сургалтын төрөл									
		Анхан шатны буюу суурь мэдлэг		Сэдэвчилсэн сургалт		Мэргэшил олгох		Мэргэжил дээшлүүлэх		Бусад	
		Хувь	Балл	Хувь	Балл	Хувь	Балл	Хувь	Балл	Хувь	Балл
1	Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар	56.0	2.1	60.7	2.2	71.4	2.4	78.6	2.6	2.4	1.0
2	Аймгийн нэгдсэн эмнэлэг	55.1	2.1	72.1	2.4	72.8	2.5	72.1	2.4	5.9	1.1
3	БОЭТ	30.3	1.6	50.0	2.0	42.1	1.8	72.4	2.4	2.6	1.1
4	Бусад	33.3	1.7	75.0	2.5	33.3	1.7	83.3	2.7	0.0	1.0
5	Дүүргийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төв	41.5	1.8	74.4	2.5	66.5	2.3	80.1	2.6	8.0	1.2
6	Өрхийн эрүүл мэндийн төв	54.4	2.1	64.1	2.3	65.5	2.3	68.4	2.4	8.7	1.2
7	Сум, сум дунд, тосгоны эрүүл мэндийн төв	59.0	2.2	63.9	2.3	78.3	2.6	71.7	2.4	6.6	1.1
8	Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв	50.0	2.0	68.4	2.4	65.6	2.3	79.2	2.6	9.9	1.2
Дундаж балл		1.9		2.3		2.2		2.5		1.1	
Дундаж хувь		47.4		66.1		61.9		75.7		5.5	

Анхан шатны буюу суурь мэдлэг олгох сургалт 59,0% ССДТЭМТ, Сэдэвчилсэн сургалт 74,4% ДНЭ,ЭМТ, Мэргэшил олгох сургалт 78,3% ССДТЭМТ, Мэргэжил дээшлүүлэх сургалт 80,1% ДНЭ,ЭМТ эрүүл мэндийн байгууллага тус бүрт нь чухал хэрэгцээтэй болох харагдаж байна.

Хүснэгт 4. Удирдлагын сургалтын хэлбэр эрүүл мэндийн байгууллага

№	Албан тушаал	Зайн сургалт		Танхимын сургалт		Ажлын байран дах сургалт	
		Хувь	Балл	Хувь	Балл	Хувь	Балл
1	Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар	48.8	2.0	85.7	1.7	9.5	0.2
2	Аймгийн нэгдсэн эмнэлэг	45.6	1.9	86.0	1.7	24.3	0.5
3	БОЭТ	23.7	1.5	88.2	1.8	5.3	0.1
4	Бусад	58.3	2.2	75.0	1.5	8.3	0.2
5	Дүүргийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төв	47.7	2.0	77.3	1.5	16.5	0.3
6	Өрхийн эрүүл мэндийн төв	47.1	1.9	74.3	1.5	15.5	0.3
7	Сум, сум дунд, тосгоны эрүүл мэндийн төв	45.1	1.9	88.9	1.8	11.1	0.2
8	Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв	47.2	1.9	86.3	1.7	17.9	0.4
Дундаж балл		1.9		1.7		0.3	
Дундаж хувь		45.4		82.7		13.5	

Сургалтын хэлбэрийг эрүүл мэндийн байгууллагаар нь харьцуулан харахад нийт эрүүл мэндийн байгууллагуудад танхимын сургалт хэрэгцээтэй байна. Түүнчлэн 48.8% нь Аймаг нийслэлийн эрүүл мэндийн газарт нь зайн сургалт, 24,3% нь Аймгийн нэгдсэн эмнэлэгт ажлын байран дах сургалт хэрэгцээтэй болох нь харагдаж байна.

Хүснэгт 5. Удирдлагын сургалтын төрлийг албан тушаалтай харьцуулалт

№	Албан тушаал	Сургалтын төрөл									
		Анхан шатны буюу суурь мэдлэг		Сэдэвчилсэн сургалт		Мэргэшил олгох		Мэргэжил дээшлүүлэх		Бусад	
		Хувь	Балл	Хувь	Балл	Хувь	Балл	Хувь	Балл	Хувь	Балл

1	Албаны дарга	45.5	1.9	76.4	2.5	70.3	2.4	82.1	2.6	7.7	1.2
2	Дарга, захирал	54.9	2.1	62.7	2.3	70.8	2.4	72.3	2.4	6.7	1.1
3	Орлогч/ дэд захирал	43.8	1.9	75.0	2.5	57.8	2.2	89.1	2.8	9.4	1.2
4	Тасгийн эрхлэгч	50.0	2.0	62.6	2.3	62.6	2.3	69.2	2.4	6.6	1.1
Дундаж балл		2.0		2.4		2.3		2.6		1.4	
Дундаж хувь		48.5		69.2		65.4		78.2		9.4	

Сургалтын төрлийг албан тушаалтай нь харьцуулан харахад нийт эрүүл мэндийн байгууллагын удирдлагуудад мэргэжил дээшлүүлэх сургалт хэрэгцээтэй байна. Түүнчлэн 76,4% албаны дарга нарт сэдэвчилсэн сургалт, 54,9% нь буюу зарим Дарга/захирал нарт анхан шатны сургалт мөн 70,8%-д нь мэргэшил олгох сургалт хэрэгцээтэй болох нь харагдаж байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

1. Сүүлийн таван жилийн хугацаанд 68,9%-д нь Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвийн удирдлагуудад дийлэнх сургалт зохион байгуулагдаж 0,8% нь Сум дундын эмнэлэг, 6,9% нь Сумын эрүүл мэндийн төв, 8,5% нь Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд сургалт цөөн тоогоор зохион байгуулагдсан байна. Албан тушаалын хувьд 8,5% нь Орлогч/дэд захирал, 23,1% нь Дарга/захирал, 25,6% нь Алба/хэлтсийн дарга, 42,8% нь Тасгийн эрхлэгч нар сургалтад хамрагдаж сургалтын хугацаа 1-2 хоног, сэдэв нь стратеги удирдлага, ерөнхий удирдлага, манлайлал, хувь хүний менежментийн сургалтад түлхүү хамрагдсан байна.

Сургалт зохион байгуулсан байгууллагын хувьд 53% нь төрийн бус байгууллага зохион байгуулсан ба бусад удирдлагын сургалтыг 8% нь Их дээд сургууль, 8% нь ЭМЯ, 10% нь ЭМХТ зохион байгуулсан бөгөөд сургалтын зардал 9,3% нь улсын зардал, 9,5% нь хувь хүний зардал, 73,4% нь эрүүл мэндийн байгууллагаас гарсан байна.

2. Эрүүл мэндийн байгууллагын нийт удирдах ажилтнуудад 85,6%-д нь Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, чанар хүртээмжийн сургалт, 80,6%-д нь Эрүүл мэндийн байгууллагын стратеги төлөвлөлтийн сургалт, 78,9%-д нь Эмнэлгийн байгууллага дахь эрсдлийн удирдлагын сургалт хэрэгцээтэй байна.

Мөн Эрүүл мэндийн байгууллагын удирдах ажилтны сургалтын төрлийн хувьд 74,5% нь мэргэжил дээшлүүлэх сургалт, сургалтын хэлбэрийн хувьд 83,2% нь танхимын сургалт, 1-14 өдрийн сургалтад хамрагдах сонирхолтой байна. Удирдалгын сургалтыг албан тушаалын хувьд Дарга/Захирал, Орлогч/Дэд захирал, Албаны дарга нарт дээрх сургалтын сэдэвтэй ижил байна. Харин Тасгийн эрхлэгч нарт Эрүүл мэндийн салбар дахь түншлэл, хамтын ажиллагааны сургалт чухал хэрэгцээтэй байна.

Удирдлагын сургалт байгууллагын хувьд АНЭМГ-т Эрүүл мэндийн салбарын төлөв байдал бодлогын тойм сургалт, Эрүүл мэндийн салбар дахь нөөцийн удирдлага сургалт, Эмнэлгийн байгууллага дахь мэдээлэл, харилцааны сургалт ДНЭМ, ЭМТ-д Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийн сургалт, Эрүүл мэндийн хөтөлбөр, төлөвлөлт, үнэлгээний сургалт, Эмнэлгийн байгууллага дахь эрсдлийн удирдлагын сургалт, ССДТЭМТ-д Эрүүл мэндийн байгууллагын стратеги төлөвлөлтийн сургалт, АНЭ-т Эрүүл мэндийн салбар дахь түншлэл, хамтын ажиллагааны сургалт тус тус хэрэгцээтэй байна.